



ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитынтайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 96455444

И-мэйл j.beegii@gmail.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллага 2-р ордон

Цахим хуудас: www.audit.mn

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэтгэсэн тайланд ТӨВ-2017/14/СТА-ТТЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2016 оны төсвийн санхүүгийн нэтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэтгэсэн тайлангийн аудитыг 2017 оны 03 дүгээр сарын 05-наас 2017 оны 03 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Ж.Бямбацогт хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2016 оны төсвийн нэтгэсэн санхүүгийн тайланг 2017 оны 03 дугаар сарын 05-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 03 дүгээр сарын 05-наас 2017 оны 03 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 31-нд Төв аймгийн Аргалант сумын Засаг даргад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн Ерөнхийлөн захирагч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна”, мөн хуулийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” 29.1.1 “төлөвлөлт, төсөв, санхүү, бүртгэл тооцооны талаар: а/нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” хэлнэ гэж заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Засаг дарга буюу ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.7 “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллага, Засгийн газрын тусгай сан, гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн тайлан бүхий хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Мөн хуулийн 14.3 Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.

Засаг дарга нь дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон, урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр санхүүжилтийн хуваарилалт хийх саналаа орон нутгийн төсвийн төслийн хамт бэлтгэж, хуульд заасан хугацааны дотор зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.Төсвийн

ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2016 оны төсвийн нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Аргалант сумын Засаг дарга, санхүүгийн албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан 9 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн системтэй танилцахад санхүүгийн тайланг Сангийн яамны и-тайлангийн нэгтгэлээр нэгтгэгдсэн санхүүгийн тайланг ирүүлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын төсвийн нэгтгэсэн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг тодоруулахад Дэлхийн банкны төслийн хүрээнд хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцсэн интернетэд суурилсан программ хангамжийг ашиглан “Санхүүгийн тайлангийн И- бланс” программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын ажлын хэсэг нь ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг гарган засаг даргын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланг е-тайлангийн бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төв аймгийн Аргалант сум 2016 оны төсвийн орлогыг 3 шатанд 149,802.5 мянган төгрөгийн төсвийн эх үүсвэр бүрдүүлэхээр баталсанаас гүйцэтгэлээр 183,593.1 мянган төгрөг буюу 122.6 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 1,370.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 9,762.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж батлагдсан төлөвлөгөө 612.6 хувиар давж биелсэн байна.

Аймагт төвлөрүүлэх татварын орлого 113,087.5 мянган төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 124,402.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөө 10.0 хувиар давж биелсэн байна.

Орон нутагт төвлөрүүлэх орлого 10 нэр төрлийн 35,345.0 мянган төгрөг бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 49,431.0 мянган төгрөг төвлөрүүлж батлагдсан төлөвлөгөө 139.9 хувиар биелсэн байна.

ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Татварын төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
ААНОАТ	600.0	564.0	94.00
НӨАТ	300.0	8686.9	2895.63
Агаарын бохирдол	470.0	511.8	108.89
<u>Улсын төсөвт төвлөрүүлэх дүн</u>	<u>1370.0</u>	<u>9762.7</u>	<u>712.61</u>
АТБӨЯХ-ийн татвар	3000.0	4174.2	139.14
Газрын төлбөр	26460.0	36035.1	136.19
Үл хөдлөх хөрөнгийн татвар	7648.9	9518.4	124.44
ХХОАТ	74149.2	72844.2	98.24
Ус ашигласны татвар	1829.4	1830.5	100.06
<u>Аймагт төвлөрүүлэх дүн</u>	<u>113087.5</u>	<u>124402.4</u>	<u>110.01</u>
Үйл ажиллагааны орлого	16872.4	7721.0	45.76
Суутгагчийн суутгасан албан татвар	4000.0	9789.8	244.75
ҮХЭХ борлуулсны татвар		210.0	#DIV/0!
Бууны албан татвар	810.0	864.0	106.67
Улсын тэмдэгтийн хураамж	4200.0	3400.5	80.96
Хог хаягдлын хураамж	1692.0	2945.0	174.05
Түрээсийн орлого	1500.0	1407.5	93.83

ТГӨО	770.6	778.3	101.00
Хүү торгуулийн орлого	3500.0	5723.4	163.53
Нэр зааж ангилагдаагүй	2000.0	16536.0	826.80
<u>Суманд төвлөрүүлэх орлого</u>	<u>35345.0</u>	<u>49375.5</u>	<u>139.70</u>

Аргалант сумын ИТХ-ын 03-р хуралдааны 2015.12.16-ны 08 тоот тогтоолоор сумын татварын орлогыг 27,574.4 мянган төгрөгөөр, татварын бус орлогыг 7770.6 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 918.4 мянган төгрөгөөр баталсан байна. ИТХ-ын төсвийн урсгал зарлагын дээд хэмжээг 33,011.5 мянган төгрөг, ЗДТГ-ын урсгал зардал 248,810.5 мянган төгрөг, ОНХС-д 44,990.4 мянган төгрөг, ЕБС-ийн төсвийг 417,705.5 мянган төгрөг, СӨБ-ийн төсвийг 164,307.6 мянган төгрөгөөр, Соёлын төвийн төсвийг 52,451.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн төсвийг 232,058.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Мал хамгаалах сан

Мал хамгаалах сан жилийн эцэст 65.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсныг ЗДТГ-ын нэмэлт данс руу төвлөрүүлж 0 үлдэгдэлгүй байна.

Байгаль хамгаалах сан

Байгаль хамгаалах сангийн оны эхний үлдэгдэл 1205.1 мянган төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данс руу төвлөрүүлж оны эцэст 0 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сан

Сумын ОНХС нь оны эхэнд 36.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 60,163.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 44,990.4 мянган төгрөг зарцуулагдаж, оны эцсийн харилцах дансны үлдэгдэл 19,148.4 төгрөг байна.

Сум хөгжүүлэх сан

Сум хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 1,952.3 мянган төгрөг, зээлийн эргэн төлөлтөөс 85,773.3 мянган төгрөг, тайлант онд зээлолгоогүй бөгөөд оны эцэст 87,196.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Эм эргэлтийн сан, Эрүүл мэндийн төвийн тайлангуудыг хувийн аудитаар хийгдэж тайланг тусад хүргүүлсэн.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан 10 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна .

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2016 оны төсвийн нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад цаг хугацааны хязгаардагдмал байдлаас шалтгаалан үндсэн цалингийн зардлыг дүнгээр тулган шалгасан ба санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг

шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Орон нутгийн орлогыг төсвийн 4795.1 мянган төгрөгийн татварын орлогыг орлогын дансанд тушаалгүй ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд үлдэгдлээр тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 “Татварын орлого нь Татварын ерөнхий хуулиар тогтоосон албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ”, 23.8 “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, НББ-ийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: 4795.1 мянган төгрөгийн орон нутгийн татварын дансанд тушаах акт тогтоов.

2. Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелсэн боловч тэмдэгтийн хураамж, түрээсийн орлого тасарсан нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 “Татварын орлого нь Татварын ерөнхий хуулиар тогтоосон албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ”, 23.8 “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Татварын орлогыг нэр төрлөөр ханган биеолүүлэх албан шаардлага бичив.

3. Сум хөгжүүлэх сангийн Үр дүнгийн тайлангийн орлого, зарлагад 529.9 мянган төгрөгийг хий бичилт хийсэн, зээлийн хүүгийн авлага, зээлийн авлагыг тус тус тусад нь бүртгэж тайлагнаагүй нь НББ-ийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, тохиолдсон байх, оршин байх, үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн: Зээлийн хүүгийн орлогыг тайлант үеийн орлогоор тайлагнах, зээлийн авлага, хүүгийн авлагыг тусад нь бүртгэж тайлагнаж байх зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй алдаануудынталаарх тайлбар:

Аудитын явцад алдаа залруулаагүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй Сум хөгжүүлэх сангийн зээл олголт, эргэн төлөлтийг давтан шалгах асуудлыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2016 төсвийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний 243354.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн зөрчлийг баталгаажуулж, 4795.1 мянган төгрөгийн акт, 529.9 мянган төгрөгийн албан шаардлага, зөвлөмж хүргүүлэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын төсвийн 2016 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд Төв аймгийн Аудитын газраас 2 зөвлөмж өгсөнийг хангалттай хэрэгжүүлж ирсэн байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Хязгаарлалттай санал дүгнэлт

Төв аймгийн Аргалант сумын Засаг дарга, ТТЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд хамрагдсан төсвийн байгууллагууд дараах санал дүгнэлт авсан байна.Үүнд:

Засаг даргын тамгын газар зөрчилгүй санал дүгнэлт
Иргэдийн төлөөлөгчдийн хурал зөрчилгүй санал дүгнэлт
Ерөнхий боловсролын сургууль зөрчилгүй санал дүгнэлт
Цэцэрлэг зөрчилгүй санал дүгнэлт
Эрүүл мэндийн төв зөрчилгүй санал дүгнэлт
Соёлын төв зөрчилгүй санал дүгнэлт

Аудитлагдсан санхүүгийн тайлан 12 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Ж.БЯМБАЦОГТ